

## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр

№ 22/22

Улаанбаатар хот

### **Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Капитрон банкнаас энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. Капитрон банктай энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. Капитрон банктай байгуулсан Зээлийн болон Барьцааны гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 09 дүгээр сарын 07 -ны өдөр

№ 22/23

Улаанбаатар хот

**2022 оны санхүүгийн тайланд аудит хийх  
хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ ”)-ийн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Мэдээлэл-Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. Компанийн дотоодын болон олон улс дахь нэр хүнд, бизнесийн салбар дахь байр суурь, түүнчлэн Компанийн оролцогч нь болсон “АНД Глобал” группын бусад компанид тавигддаг шаардлагын дагуу Компанийн 2022 оны санхүүгийн тайланд нэмэлтээр хөндлөнгийн аудит хийлгэх, ийнхүү хийлгэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагуудын нэг болох “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай хамтран ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. “Мэдээлэл-Аудит” ХХК болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай байгуулах холбогдох гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
4. Хөндлөнгийн аудитын байгууллагуудыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



**ТУЗ-ИЙН ДАРГА**

**О.БОЛДБААТАР**